

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/11/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/62
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА С.МӨНХТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020257

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	323,046,090.27	1,041,332,125.61
33	АВЛАГА	2,150,000.00	5,000,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	5,000,000.00
335	Бусад авлага	2,150,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	2,150,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	320,896,090.27	1,036,332,125.61
351	Түүхий эд материал	207,062,556.79	762,153,912.51
35110	Тусгай зориулалттай материал	2,295,700.00	2,295,700.00
35130	Эм боох материал	204,766,856.79	759,858,212.51
354	Хангамжийн материал	113,833,533.48	274,178,213.10
35410	Бичиг хэргийн материал	1,242,125.00	2,312,375.00
35420	Аж ахуйн материал	229,450.00	917,550.00
35440	Түлш, шатах тослох материал	2,933,450.00	10,434,405.00
35450	Барилгын засварын материал	5,009,700.00	5,009,700.00
35460	Хүнсний материал	1,110,600.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	103,308,208.48	255,504,183.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	886,220,338.57	916,121,037.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	886,220,338.57	916,121,037.13
392	Биет хөрөнгө	772,215,338.81	757,669,637.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,815,865.55	618,815,865.55
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,078,307.53	-69,100,752.37
39203	Авто-тээврийн хэрэгсэл	286,183,256.00	276,851,297.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-136,943,017.74	-156,406,415.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	200,763,097.32	257,766,438.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-184,632,243.91	-190,195,401.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,594,347.36	101,837,591.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,705,927.44	-81,898,985.33
39217	Ном	8,218,269.20	00.00
393	Биет бус хөрөнгө	114,004,999.76	158,451,399.72
39301	Програм хангамж	2,057,500.00	2,057,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,977,500.24	-1,997,500.28
39303	Бусад биет бус хөрөнгө	113,925,000.00	158,391,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,209,266,428.84	1,957,453,162.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,209,266,428.84	1,957,453,162.75
51	Засгийн газрын хувь оролцоо	1,209,266,428.84	1,957,453,162.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	1,097,766,471.77	1,142,232,871.77
51101	Өмч: - төрийн	983,841,471.77	983,841,471.77
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	113,925,000.00	158,391,400.00
512	Хуримтлагдсан үр дүн	-127,961,250.38	575,912,817.01
51210	Өмнөх үеийн үр дүн	-127,961,250.38	-127,807,516.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	703,720,333.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,461,207.45	239,307,473.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,209,266,428.84	1,957,453,162.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,015,037,095.18	11,842,936,314.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	491,902,969.18	7,541,294,122.95
120	Нийтлэг татварын бус орлого	491,902,969.18	7,541,294,122.95
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	12,591,300.00	49,263,345.35
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	479,311,669.18	7,492,030,777.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,523,134,126.00	4,301,642,191.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,329,031,900.00	2,573,503,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,329,031,900.00	2,573,503,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	194,102,226.00	1,728,138,391.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	48,399,626.00	181,568,849.99
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,546,800.00	198,768,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,155,800.00	1,317,845,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	29,955,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,193,003,540.34	4,357,680,080.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,193,003,540.34	4,357,680,080.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,286,062,641.74	1,384,314,112.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,814,841.97	570,028,368.62
210101	Үндсэн цалин	570,814,841.97	346,519,221.94
210102	Нэмэгдэл	00.00	146,478,575.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	42,060,000.00
210104	Урамшуулал	00.00	34,970,571.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,957,849.20	76,406,929.01
210201	Тэтгэврийн даатгал	52,414,826.57	54,865,480.04
210202	Тэтгэмжийн даатгал	5,942,108.14	5,465,455.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,632,728.51	4,355,684.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,087,381.18	1,065,491.80
210205	Эрүүл мэндийн даатгал	10,880,804.80	10,654,817.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,991,100.00	79,896,730.00
210301	Гэрэл, цахилгаан	7,283,724.00	6,735,994.00
210302	Түлш, халаалт	67,480,248.00	67,480,248.00
210303	Цэвэр, бохир ус	4,227,128.00	5,680,488.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,009,788.72	76,524,366.00
210401	Бичиг хэрэг	5,862,075.00	7,184,550.00
210402	Тээвэр, шатахуун	46,450,410.00	52,721,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,468,500.00	6,492,053.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,822,100.00	9,646,323.00
210408	Бараа материал акталсны зардал	3,926,703.72	00.00
2105	Нормативт зардал	92,719,206.37	171,797,668.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,719,206.37	171,797,668.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,008,752.50	95,069,531.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	45,138,197.50	82,272,971.60
210604	Урсгал засвар	22,870,555.00	12,796,560.00
2107	Томиллолт, зочны зардал	13,280,000.00	33,554,400.00
210702	Дотоод албан томиллолт	13,280,000.00	33,554,400.00

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,003,595.00	16,523,765.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,719,120.00	7,493,345.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	2,220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	188,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,252,000.00	4,661,100.00
210807	Газрын төлбөр	341,475.00	351,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	313,277,507.98	264,512,353.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	215,956,301.23	189,412,576.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,860,000.00	7,520,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,461,206.75	67,579,777.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	906,940,898.60	2,973,365,968.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	901,164,900.00	2,962,467,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,217,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	489,879,000.00	827,739,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	369,604,600.00	862,547,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,681,300.00	54,780,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,853,998.60	10,898,668.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,853,998.60	10,898,668.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	3,922,000.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,922,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	822,033,554.84	7,485,256,234.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	679,075,343.45	6,781,170,400.46
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	8,218,269.20
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	16,719,300.00	205,149,788.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	662,356,043.45	6,568,167,843.26
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-679,075,343.45	-6,781,535,900.46
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	142,958,211.39	703,720,333.91

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,097,766,471.77	240,639,297.24	-326,793,099.06	00.00	1,011,612,669.95
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,097,766,471.77	240,639,297.24	-326,793,099.06	00.00	1,011,612,669.95
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	122,427,913.96	00.00	122,427,913.96
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,097,766,471.77	239,461,207.45	-127,961,250.38	00.00	1,209,266,428.84
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,097,766,471.77	239,461,207.45	-127,961,250.38	00.00	1,209,266,428.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	153,733.48	00.00	153,733.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,097,766,471.77	239,461,207.45	-127,807,516.90	00.00	1,209,420,162.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-153,733.48	00.00	00.00	-153,733.48
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	44,466,400.00	00.00	00.00	00.00	44,466,400.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	703,720,333.91	00.00	703,720,333.91
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,142,232,871.77	239,307,473.97	575,912,817.01	00.00	1,957,453,162.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,523,134,126.00	4,303,792,191.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,523,134,126.00	4,303,792,191.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,329,031,900.00	2,573,503,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,329,031,900.00	2,573,503,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	194,102,226.00	1,730,288,391.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	48,399,626.00	181,568,849.99
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,546,800.00	198,768,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,155,800.00	1,317,845,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	32,105,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,514,986,226.00	4,291,823,191.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,514,986,226.00	4,291,823,191.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,608,045,327.40	1,313,457,223.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,814,841.97	570,028,368.62
210101	Үндсэн цалин	379,026,282.73	346,519,221.94
210102	Нэмэгдэл	110,534,964.38	146,478,575.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,196,632.73	42,060,000.00
210104	Урамшуулал	37,056,962.13	34,970,571.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,957,847.43	76,406,929.02
210201	Тэтгэврийн даатгал	52,520,647.43	54,865,480.05
210202	Тэтгэмжийн даатгал	5,609,300.00	5,465,455.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,487,400.00	4,355,684.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,121,900.00	1,065,491.80
210205	Эрүүл мэндийн даатгал	11,218,600.00	10,654,817.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,991,100.00	79,896,730.00
210301	Гэрэл, цахилгаан	7,283,724.00	6,735,994.00
210302	Түлш, халаалт	67,480,248.00	67,480,248.00
210303	Цэвэр, бохир ус	4,227,128.00	5,680,488.00
2104	Хангамж, бараа материалын зардал	53,514,900.00	71,068,566.00
210401	Бичиг хэрэг	4,854,400.00	6,344,400.00
210402	Тээвэр, шатахуун	42,212,000.00	52,261,945.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,468,500.00	6,035,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	5,947,031.00
2105	Нормативт зардал	503,883,500.00	150,035,902.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	501,779,500.00	147,931,902.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,104,000.00	2,104,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,640,405.00	15,001,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,840,000.00	1,043,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	2,708,600.00
210604	Урсгал засвар	28,091,805.00	11,250,000.00
2107	Томилот, зочны зардал	13,280,000.00	33,554,400.00
210702	Дотоод албан томилот	13,280,000.00	33,554,400.00

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,445,695.00	17,583,765.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	4,129,220.00	7,343,345.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	2,220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	188,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,284,000.00	5,871,100.00
210807	Газрын төлбөр	341,475.00	351,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	261,517,038.00	299,880,963.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	259,434,138.00	292,040,963.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,082,900.00	7,840,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	906,940,898.60	2,978,365,968.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	901,164,900.00	2,962,467,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,217,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	489,879,000.00	827,739,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	369,604,600.00	862,547,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,681,300.00	54,780,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,775,998.60	15,898,668.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,853,998.60	15,898,668.35
213304	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,922,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,147,900.00	11,969,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,147,900.00	11,969,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,147,900.00	11,969,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,147,900.00	11,969,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,147,900.00	11,969,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,147,900.00	-11,969,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангил	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,573,503,800.00	2,562,625,206.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,573,503,800.00	2,562,625,206.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	882,436,500.00	871,557,906.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,563,800.00	539,403,434.62
210101	Үндсэн цалин	330,110,000.00	315,894,287.94
210102	Нэмэгдэл	111,492,300.00	146,478,575.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,045,000.00	42,060,000.00
210104	Урамшуулал	54,916,500.00	34,970,571.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,971,100.00	72,272,563.02
210201	Тэтгэврийн даатгал	50,868,600.00	50,731,114.05
210202	Тэтгэмжийн даатгал	5,775,600.00	5,465,455.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,620,500.00	4,355,684.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,155,100.00	1,065,491.80
210205	Эрүүл мэндийн даатгал	11,551,300.00	10,654,817.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,560,500.00	79,896,730.00
210301	Гэрэл, цахилгаан	8,028,300.00	6,735,994.00
210302	Түлш, халаалт	67,480,200.00	67,480,248.00
210303	Цэвэр, бохир ус	8,052,000.00	5,680,488.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,481,200.00	64,218,621.00
210401	Бичиг хэрэг	6,344,400.00	6,344,400.00
210402	Тээвэр, шатахуун	45,412,000.00	45,412,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,784,800.00	6,035,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	5,947,031.00
2105	Нормативт зардал	18,263,000.00	18,242,402.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,159,000.00	16,138,402.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,104,000.00	2,104,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,458,600.00	16,458,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	2,708,600.00
210604	Урсгал засвар	11,250,000.00	11,250,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,500,000.00	6,500,000.00
210702	Дотоод албан томилолт	6,500,000.00	6,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам	24,624,000.00	21,611,965.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	7,632,000.00	7,343,345.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,770,000.00	2,220,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	188,320.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	9,899,300.00
210807	Газрын төлбөр	351,000.00	351,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53014300.00	52953591.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,174,300.00	45,113,591.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,840,000.00	7,840,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,691,067,300.00	1,691,067,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,691,067,300.00	1,691,067,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	827,739,500.00	827,739,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	862,547,800.00	862,547,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	780,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,573,503,800.00	2,573,503,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,573,503,800.00	2,573,503,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,573,503,800.00	2,573,503,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	43.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	32.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	190,180,226.00	1,725,268,317.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	190,180,226.00	1,725,268,317.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	190,180,226.00	453,868,317.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	30,624,934.00
210101	Үндсэн цалин	-	30,624,934.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	4,134,366.00
210201	Тэтгэврийн даатгал	-	4,134,366.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,310,000.00	6,849,945.00
210401	Бичиг хэрэг	510,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	11,800,000.00	6,849,945.00
2105	Нормативт зардал	63,720,500.00	131,793,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,720,500.00	131,793,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,890,000.00	895,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,890,000.00	895,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,280,000.00	27,054,400.00
210702	Дотоод албан томилолт	5,280,000.00	27,054,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,979,726.00	252,516,172.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,979,726.00	252,516,172.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,271,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,271,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,217,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	54,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	194,102,226.00	1,730,288,391.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	194,102,226.00	1,730,288,391.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	44,750,626.00	181,568,849.99
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,546,800.00	198,768,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,155,800.00	1,317,845,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,649,000.00	32,105,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалыг ангилан бүртгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр ханган ажилладаг Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг юм.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нэн шаардлагатай мэргэшлийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх
- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний хөтөлбөр болон өөрийн орон нутгийн онцлогт тохирсон дэд хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, эрүүл мэндийн технологийн үнэлгээ, эмнэлгийн тоног, төхөөрөмжийн засвар үйлчилгээ, чанарын хяналт, шалгалт тохируулга, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх
- Болзошгүй гамшиг, онцгой байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчин, улирлын чанартай халдварт өвчний дэгдэлтийн үеийн эрсдэлийн удирдлагатай уялдсан тусламж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээ, тасралтгүй үйл ажиллагааг хангах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 23-ны А/64 тоот тушаалаар "Дотоод аудит хийх журам" батлуулсан, мөрдөн ажиллаж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн 1, дотоод аудит 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилладаг. Тайлант онд 11 арга хэмжээ бүхий дотоод аудитын багийн төлөвлөгөө боловсруулж батлуулан дотоод аудитыг хийж, зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна. Байгууллагын худалдан авах гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсэг, албан тушаалтан томилон ажиллуулж гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байна

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 101,434.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 81,147.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 64,556.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 51,645.5 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 36,877.3 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Эрүүл мэндийн газар 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл

мэндийн тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 2,573,503.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Нэмэлт санхүүжилтийн дансанд 1,730,288.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 4,291,823.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд ХӨСҮТ-ээс 49,263.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй, 11,969.0 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, Зооноз халдварт өвчин судлалын төвийн барилгын газрыг 46,466.4 мянган төгрөгөөр үнэлж, данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн ИТХ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 08-ний өдрийн 27 дугаар тогтоолоор 20,317.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан ба Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 5 дугаар сарын 18-ний өдрийн 129 дүгээр албан бичгээр бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансанд 337,211.9 мянган төгрөгийн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр худалдан авч, 7,499,316.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, харьяа газрууддаа хуваарилан хүргүүлсэн байна.

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 5,000.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/803 дугаар тушаалаар Эрүүл мэндийн ажилтнуудад олгох мөнгөн тэтгэмжийг буцаан төвлөрүүлж, авлагаар бүртгэж, баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал 1,036,332.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 916,121.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	2,150.0	5,000.0	2,850.0
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	320,896.1	1,036,332.1	715,436.0
Үндсэн хөрөнгө	886,220.3	916,121.0	29,900.7
Нийт хөрөнгө	1,209,266.4	1,957,453.2	748,186.8
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,209,266.4	1,957,453.2	748,186.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,209,266.4	1,957,453.2	748,186.8

Бараа материалын дансны үлдэгдэл 1,036,332.1 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 715,436.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 916,121.0 мянган төгрөг болж 29,900.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 105,698.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,957,453.2 мянган төгрөг болж 748,186.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 703,720.3 мянган төгрөгөөр, эздийн өмчийн хэсэг 44,466.5 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 2,913,954.8 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 362,663.2 мянган төгрөгөөр бууруулан 2,551,291.5 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин, нэмэгдэл, шимтгэлийн зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 2,573,503.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төлөвлөгөөний дагуу 2,562,625.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 10,878.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,562,625.2 мянган төгрөг буюу 99,6 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМЯ-аас 1,317,245.7 мянган төгрөгийн санхүүжилтийг Ковид-19-ын халдварын эрсдэлтэй голомтот бүсэд ажил үүргээ гүйцэтгэж байгаад халдвар авсан болон иргэнийг эмчлэх арга хэмжээнд ажилласан эмнэлгийн ажилтан, эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах зорилгоор олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжид, Монголын сумын эмч мэргэжилтний холбооноос 41,178.5 мянган төгрөг сүрьеэгийн урьдчилсан үзлэгийн арга хэмжээнд, ДЭМБ-аас 140,390.3 мянган төгрөг КОВИД-19 цар тахлын эсрэг Төв аймгийн хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх төсөлд, аймгийн Засаг даргын захирамжаар 198,768.3 мянган төгрөг ХӨСҮТ-өөс 600.0 мянган төгрөг томуу өвчний сургалтын зардалд, 27,972.5 мянган төгрөг түргэвчилсэн оношлуурын үнэнд, 2,150.0 мянган төгрөгийн авлага, 1,983.1 мянган төгрөгийг гэрчилгээ, шинжилгээний үнэнд, нийт 1,730,288.4 мянган төгрөг төвлөрсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулах эрх нээлгэж цалин, шимтгэлийн зардалд 34,759.3 мянган төгрөг, тээвэр шатахуунд 6,849.9 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэлд 131,793.5 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 895.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 27,054.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 252,516.2 мянган төгрөгийн, эмнэлгийн ажилтан албан хаагчдад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 1,271,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 5,020.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 5 дугаар сарын А/298 дугаар тушаалаар аймгуудад Коронавирусын халдварын эрсдэлтэй голомтот бүсэд ажил үүргээ гүйцэтгэж байгаад халдвар авсан болон иргэнийг эмчлэх арга хэмжээнд ажилласан эмнэлгийн ажилтанд олгохоор 54,000.0 мянган төгрөг ирснийг Эрүүл мэндийн газрын даргын А/38 тушаалаар аймгийн Нэгдсэн Эмнэлэг, ЭМГ, СЭМТ -ийн нийт 111 эмч, эмнэлгийн ажилтанд олгосон байна.

Эрүүл мэндийн сайдын А/248 дугаар тушаалаар аймгийн Эрүүл мэндийн газарт Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор халдварын тандалт, сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалтын арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн ажилтанд илүү цагийн хөлсийг Эрүүл мэндийн газрын даргын А/40 тушаалаар 30,624.9 мянган төгрөг олгосон байна.

Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг урамшуулах зорилгоор нэг удаагийн мөнгөн тэтгэмжид Эрүүл мэндийн сайдын А/496 дугаар тушаалаар 967,000.0 мянган төгрөг, А/585 дугаар тушаалаар 250,400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг Эрүүл мэндийн газрын даргын Б/51, Б/37 дугаар тушаалаар тус тус хуваарилан олгосон байна.

Аймгийн Засаг даргаас захирамжаар Ковид-19 халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ, “Нэг Өрх-Нэг шинжилгээ”, бүх иргэдийг дархлаажуулах үйл ажиллагаанд нийт 198,768.3 мянган төгрөг санхүүжигдсэн байна.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр КОВИД-19 цар тахлын эсрэг Төв аймгийн хариу арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна.

ЭМЯ-аас үнэ төлбөргүй ирүүлсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан эсэхийг тулгахад хөрөнгийн нэг бүрийн үнэ, тоо ширхэг зөрүүтэй байсныг зарлагын баримтын дагуу данс бүртгэлд тусгасан ба 160,871.9 мянган төгрөгийн хуваарилсан орлого ирээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд ХӨСҮТ-ээс 49,263.3 мянган төгрөгийн хөргөгч, вакцины гүн хөлдөөгч хөргөгчийг үнэ төлбөргүй, 11,969.0 мянган төгрөгийн пос машин, принтер, тоног төхөөрөмж зэргийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Зооноз халдварт өвчин судлалын төвийн барилга барихаар төлөвлөн, Зуунмод сумаас нийт 5053 м2 газар эзэмшүүлснийг 46,466.4 мянган төгрөгөөр үнэлж, данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн ИТХ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 08-ний өдрийн 27 дугаар тогтоолоор 20,317.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан ба Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 5 дугаар сарын 18-ний өдрийн 129 дүгээр албан бичгээр бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансанд аймгийн Засаг даргын захирамжаар 210,070.9 мянган төгрөгийг корона вирус халдварын эсрэг бэлэн байдлыг хангах зорилгоор түргэвчилсэн оношлуур, тандалт сэргийлэлт, дархлаажуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад зарцуулж, 26 сумын Эрүүл мэндийн төв, өрх аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлсэн байна.

ХӨСҮТ-өөс 6,219,839.5 мянган төгрөгийн, ЭМЯ-аас 1,050,724.6 мянган төгрөгийн, аймгийн Онцгой байдлын газраас 15,764.4 мянган төгрөгийн, аймгийн Онцгой комиссоос 155,845.0 мянган төгрөгийн эм вакцин, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн маск, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, түргэвчилсэн оношлуур зэргийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэн сумдын Эрүүл мэндийн төвүүд, өрх, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлсэн байна.

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалин, нэмэгдэл урамшууллын зардалд горим сорил хэрэгжүүлээгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Худалдан авах ажиллагаа, тендер сонгон шалгаруулалт нь гүйцэтгэлийн аудитад хамрагдах болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд байршуулсан төлөвтэй байгаа ба Ковид-19 цар тахалтай холбоотой материаллаг хандив, тусламжийн орлого, зарцуулалтын мэдээг 12 дугаар сард, Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг бүтэн жилээр байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн 1/405 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,685,803.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 69,107.2 мянган төгрөгийн албан шаардлага, 5,610,696.7 мянган төгрөгийн материаллаг бус зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Санхүү тайланд залруулга хийгдээгүй байна.

4.2 Төлбөрийн акт

Шатах тослох материал нь жилийн эцсийн байдлаар 10,064.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тус байгууллагын жилийн батлагдсан төсөвтэй харьцуулахад 2.5 сарын хэрэгцээтэй тэнцэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-д “төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг”, 7 дугаар зүйлийн 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна”, 7.6-д “Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ” гэсэн заалтыг болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэж заасны дагуу тус байгууллагын нэг сарын шатахууны хэрэгцээнд 4,064.4 мянган төгрөгийг үлдээж, илүү нөөц бүрдүүлсэн 6,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичихээр шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

АШБ-ын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагаас ирүүлсэн е баримттай тулган шалгахад 68,434.5 мянган төгрөгийн гүйлгээ е баримтын дүнгээс зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Хүнсний материал дансанд тайлант хугацаанд ажиллагсдыг тусгаарлалтад байх үеийн хүнсний материалыг тайлагнасан ба үүнээс 672.7 мянган төгрөгөөр чихэр, кофе зэргийг бэлтгэн зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг

зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “хэмжилт”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 17 удаагийн орлогоор 5,610,696.7 мянган төгрөгийн вакцин, эмийг орлогоор бүртгэхдээ вакцин, эм, эмнэлгийн хэрэгслийг бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эм, боох материалын дансанд вакцин, эм, эмнэлгийн хэрэгслийг орлогоор бүртгэхдээ бөөн дүнгээр бүртгэж, тайлагнасан зөрчлийг таслан зогсоож, эм, эмнэлгийн хэрэгслийн орлогыг нэр төрөл бүрээр тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Эрүүл мэндийн газар	4	5,685,803.9	0	0	1	6,000.0	2	69,107.2	1	5,610,696.7

